



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 14 өдөр

Дугаар A/102

Хэрлэн сум

Дуудлагын худалдаа зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 38 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нээлттэй дуудлагын худалдаагаар үнэ бууруулж худалдах автомашинуудын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулах комиссыг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Ц.Дэмбэрэлсайхан -Орон нутгийн өмчийн газрын дарга

Хөтлөгч: О.Баяртөгс -Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Тэмдэглэл хөтлөгч: Л.Оюунтуяа -Орон нутгийн өмчийн газрын нягтлан бодогч, бичиг хэргийн ажилтан

3. Нээлттэй дуудлагын худалдааг 2018 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 10.00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын 304 тоот өрөөнд зохион байгуулсугай.

4. Нээлттэй дуудлагын худалдааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Дэмбэрэлсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА



Аймгийн Засаг даргын 2018 оны 03  
дугаар сарын өдрийн 03 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт

ҮНЭ БУУРУУЛЖ ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

д/д	Байгууллага	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэгдсэн он	Орж ирсан он	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ	Хуримтла гдсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Үнийн санал			
										Сэргээн босголтын зардал /сүүлийн 3-н жилийэр/	Анх тогтоосон	Буурсан үнэ	Үүнээс аймгийн төсөвт
1	Аймгийн Цагдаагийн газар	Ниссан пулсар 01 -02ХЭҮ автомашин	2007	2007	1	4 536 000	4 536 000	4 536 000	-		1 000 000	200 000	200 000
2	Аймгийн Цагдаагийн газар	Ниссан куби 61-58 ХЭА автомашин	1999		1	5 000 000	5 000 000	5 000 000	-	-	2 000 000	200 000	200 000
Дүн							9 536 000	9 536 000	-	0,0	3 000 000	400 000	400 000